

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН 2007 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2007 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр

Улаанбаатар хот

НЭГ.ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2007 оны 9 дүгээр сарын 31-ны өдрийн байдлаар Санхүүгийн Зохицуулах Хорооноос хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нийт 131 хоршоонд холбогдох хууль, журмийн дагуу олгоод байна. Тусгай зөвшөөрөл бүхий ХЗХ-доос “Арлужин” ХЗХ /УБ хот/, “Спейшил-резерв” ХЗХоршоо/УБ хот/-д татан буугдахаар өргөдөл холбогдох материалаа тус Хороонд ирүүлээд байгаа бөгөөд 129 ХЗХ-дын санхүүгийн тайлан нэгтгэхээс 19 ХЗХ /14.5%/ тайлангаа ирүүлээгүй, 14 ХЗХ /10.7%/-ны тайлан алдаатай ирүүлсэн учир 97 ХЗХ /74%/-ны санхүүгийн болон зохистой харьцааны тайлан нэгтгэгдсэн болно.

Доорхи 19 хадгаламж, зээлийн хоршоод холбогдох журмын дагуу санхүүгийн тайлан болон зохистой харьцааны тайлангаа зохих цаг хугацаанд нь Хороонд ирүүлээгүй байна.

1. Дөргөн хөгжил ХЗХ
2. Гандарьмаа ХЗХ
3. Хүнгэлдуут ХЗХ
4. Тэгш таван цэн ХЗХ
5. Тосон есөн булаг ХЗХ
6. Ойгоны ирээдүйн сэтгэмж ХЗХ
7. Үлэмж арвижих ХЗХ
8. Приват кредит ХЗХ
9. Май капитал ХЗХ
10. Пенни ХЗХ
11. Эко хөгжил ХЗХ
12. Сумма ХЗХ
13. Юнайтед инвесторс ХЗХ
14. Фүжи партнерс ХЗХ
15. Далай арвижих ХЗХ
16. Мантаг ХЗХ
17. Эс си инвест ХЗХ
18. Си ди ко ХЗХ
19. Шилийн зоо ХЗХ


Дээрх тайлангаа ирүүлээгүй хадгаламж, зээлийн хоршоодын 53% буюу 10 ХЗХ нь Улаанбаатар хотод, 47% буюу 9 ХЗХ нь хөдөө, орон нутагт үйл ажиллагаа явуулдаг хоршоод байна. Энэ нь тайлангаа ирүүлээгүй ХЗХ-г нийт ХЗХ-дтой харьцуулахад хөдөө, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хоршоодын дийлэнх нь санхүүгийн тайлан болон холбогдох тайлан мэдээгээ ирүүлэхгүй байна.

Тусгай зөвшөөрөл бүхий ХЗХ-доос 2007 оны 3 дугаар улиралын санхүүгийн тайлан, холбогдох мэдээлэлээ доорх хоршоод нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу бус, алдаатай гаргаж тус Хороонд ирүүлсэн байна. Үүнд:


1. Аврагас зоос ХЗХ
2. Түмэнтий инвест ХЗХ
3. Мөнгөн зоос финанс ХЗХ
4. Монконкорд ХЗХ
5. Монос дэлгэрэх ХЗХ
6. Эмпипи ХЗХ
7. Найманжандаг ХЗХ
8. Андын сор ХЗХ
9. Говийн хишиг ХЗХ
10. Зуун айл ХЗХ
11. Мөнхийн хүрд ХЗХ
12. Дэлгэр дэнж ХЗХ
13. Тэргүүн зоос ХЗХ
14. Мон сант алдар ХЗХ

Дээрх алдаатай санхүүгийн тайлан ирүүлсэн хоршоодын 35% нь буюу 5 ХЗХ хөдөө, орон нутагт, 65% нь буюу 9 ХЗХ нь УБ хотод үйл ажиллагаа явуулдаг хоршоод байна.

/График-1/



/График-1/-ээс харахад тусгай зөвшөөрөл бүхий хоршоодын тоо өмнөх улиралаас 5.3%-аар өссөн байна. Энэ нь улиралд дунджаар 26 хоршоонд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгогдож байгаа буюу улиралд дунджаар ХЗХ-дын тоо 25.3 % -ийн өсөлттэй байна.



/График-2/

Тус Хорооноос тусгай зөвшөөрөл нөхөн олгож байгаатай холбогдон улиралд дунджаар тусгай зөвшөөрөл бүхий хоршоодын гишүүдийн тоо 2,278 гишүүнээр нэмэгдэж байна. Нэгж ХЗХ-нд ноогдох гишүүдийн арифметик дундаж нь ойролцоогоор 109 гишүүнтэй байна./График-2/


Нийт хадгаламж, зээлийн хоршоодын 92 хоршоо нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт хоршоодын 70.2% болж байна. 39 хоршоо нь орон нутагт үйл ажиллагаа явуулж буй нь 29.8% болж байна.

1000-аас дээш гишүүнтэй	500-1000 гишүүнтэй	100-500 гишүүнтэй	20-100 гишүүнтэй
2 ХЗХ	3 ХЗХ	30 ХЗХ	96 ХЗХ
3269 гишүүн	2167 гишүүн	6859 гишүүн	1970 гишүүн
22.9%	15.2%	48.1%	13.8%

1000–аас дээш гишүүнтэй 2 ХЗХ байгаа нь нийт ХЗХ-дын гишүүдийн 22.9%, 500-1000 гишүүнтэй 3 ХЗХ байгаа нь нийт ХЗХ-дын гишүүдийн 15.2% болж байна. 100-500 гишүүнтэй 30 ХЗХ нь хамгийн их гишүүнтэй буюу 6859 гишүүн буюу нийт ХЗХ-дын гишүүдийн 48.1%-ийг эзэлж байна. Харин 20-100 гишүүнтэй 96 хоршоод нь хамгийн их байгаа боловч нийт гишүүдтэй харьцуулахад дөнгөж 13.8% тай тэнцүү байна.


ХОЁР.АКТИВ, ТҮҮНИЙ БҮТЭЦ

/График-3/



/График-3/-аас харахад Тусгай зөвшөөрөл бүхий хоршоодын нийт активийн дундаж өсөлт 5,517.5 сая төгрөг буюу улиралд дунджаар 17.15 %-аар өсөж байна. Энэ нь улирал бүр хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл тус Хорооноос хоршоодод нөхөн олгож байгаатай холбоотой юм.

/График-4/



/График-4/-өөс харахад нэгж хоршоонд ноогдох дундаж актив 2007 оны 1 дүгээр улиралаас эхлэн өссөн байна. Сүүлийн улиралд нэгж хоршоонд ноогдох дундаж актив өмнөх улиралаас 24 сая төгрөгөөр буюу 9.8 %-аар өсөж 245,5 сая төгрөг болсон байна.

2.1.Активийн бүтэц

ХӨРӨНГӨ		2007-II	2007-III	Нийт активт эзлэх хувь
1.ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		26,124,656,886.62	30,759,285,522.84	95.6%
I	МӨНГӨН ХӨРӨНГӨ	10,433,162,840.48	12,722,512,230.90	39.6%
	1.Касс дахь бэлэн мөнгө	755,150,555.89	929,921,412.79	2.9%
	2.Банк,ББСБ-д байршуулсан харилцах	2,399,719,361.48	5,905,173,984.09	18.4%
	3.Банк, ББСБ-д байршуулсан хадгаламж	5,905,173,984.09	5,905,173,984.09	17.9%
II	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	5,500.00	-	0.0%
	6. Засгийн газар болон Төв банкны үнэт цаас	5,500.00	-	0.0%
III	ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)	13,694,473,564.99	16,271,097,324.44	50.6%
	8. Нийт зээл	14,492,727,116.52	17,238,823,723.44	53.6%
	8.4.(Зээлийн эрсдэлийн сан)	(798,253,551.53)	(967,726,399.00)	-3.0%
IV	АВЛАГА (ЦЭВРЭЭР)	1,703,797,694.80	1,440,090,068.18	4.5%
V	БУСАД ХӨРӨНГӨ	94,754,141.83	74,875,566.41	0.2%
VI	ӨМЧЛӨХ БУСАД ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)	198,463,144.52	250,710,332.90	0.8%
2.ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		1,339,766,519.53	1,402,404,148.21	4.4%
VII	ҮНДСЭН ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)	1,078,525,705.03	1,174,602,214.96	3.7%
VIII	БУСАД ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	261,240,814.50	227,801,933.25	0.7%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (1+2)		27,464,423,406.15	32,161,689,671.05	100.0%

Дээрх хүснэгтээс харахад активийн зүйл бүр ерөнхийдөө өссөн дүнтэй байна. “Хадгаламж, зээлийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоож, хяналт тавих тухай журам”-ын дагуу касс дахь бэлэн мөнгөний харьцаа 2% хүртэл байхаас 0,9% илүү буюу 2,9% байна.

Нийт активт эзлэх зээлийн хэмжээ 53,6% буюу 17.2 тэрбум төгрөг байгаа нь зохистой харьцааны журамд 70-80% байхаар заасантай нийцэхгүй байна. Өөрөөр хэлбэл дахин 5,3-8,5 тэрбум төгрөгийн зээл олголт хийх боломжтой буюу зээл олголт муу байна.


2.2.Активийн бүтэц /орлого оруулах байдлаар нь/

	2007-II		2007-III	
Орлого оруулах актив	21,857,907,916.38	79.6%	27,876,362,310.25	86.7%
Орлого үл оруулах актив	6,694,777,869.70	24.4%	5,654,136,073.32	17.6%
Эрсдэлийн сангууд	(1,088,262,379.93)	-4.0%	(1,368,808,712.52)	-4.3%
НИЙТ АКТИВ	27,464,423,406.15	100.0%	32,161,689,671.05	100.0%

Нийт орлого үл оруулдаг актив нь 1,04 тэрбум төгрөгөөр буурч, орлого оруулдаг актив нь 6,02 тэрбум төгрөгөөр буюу нийт активт эзлэх хувь нь өмнөх улиралаас 7.1 %-аар өссөн дүнтэй байна. Орлого оруулах активийн нийт активт эзлэх хувь хэмжээ өндөр байх тусам хоршооны ашиг, ашигт ажиллагаанд сайнаар нөлөөлөх боловч активийн чанараас хамаардаг тул активийн чанарыг анхаарах нь зүйтэй байна.

/График-5/

Түргэн борлогдох активийн 2007 оны динамик судалгаа /төгрөгөөр/



Түргэн борлогдох активийн бүтцийг судлахад 7.31% нь мөнгөн хөрөнгө, 47.46% нь бусад банк болон бусад санхүүгийн байгууллагуудад байршуулсан харилцах, 45.23% нь банкинд байршуулсан хадгаламж байна.

ХЗХ-дын нийт түргэн борлогдох активийн сүүлийн 3 улиралд дунджаар 36.84% /4.7 тэрбум төгрөг/-аар өссөн байна.

2.3.Зээлийн бүтэц

	2007-II		2007-III	
ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)	13,694,473,564.99	94.5%	16,271,097,324.44	94.4%
8. Нийт зээл	14,492,727,116.52	100.0%	17,238,823,723.44	100.0%
8.1.Хэвийн зээл	13,027,621,779.59	89.9%	15,317,703,279.25	88.9%
8.2.Хугацаа хэтэрсэн зээл	525,387,291.21	3.6%	748,311,062.81	4.3%
8.3.Чанаргүй зээл	939,718,045.72	6.5%	1,172,809,381.38	6.8%
8.3.1. Хэвийн бус	154,032,273.31	1.1%	259,532,107.88	1.5%
8.3.2. Эргэлзээтэй зээл	282,355,004.76	1.9%	252,808,113.38	1.5%
8.3.3. Муу зээл	503,330,767.65	3.5%	660,469,160.12	3.8%
8.4.(Зээлийн эрсдэлийн сан)	(798,253,551.53)	-5.5%	(967,726,399.00)	-5.6%

Дээрх хүснэгтээс харахад нийт салбарын зээлийн багц нь 2.8 тэрбум төгрөгөөр буюу 15.93 %-аар өссөн дүнтэй байна. Нийт зээлийн багцтай харьцуулахад хэвийн зээлийн багц 1.0 %-аар буурч, хугацаа хэтэрсэн зээл 0.7 %-аар өсч, чанаргүй зээл 0.3 %-аар өссөн байна.



Өөрөөр хэлбэл нийт зээлийн багц ангилал бүр дээр буурч, нийт зээлийн багцын чанар буурсан үзүүлэлттэй байна. Үүнтэй холбогдон зээлийн эрсдэлийн сангийн хэмжээ өмнөх улиралаас 17,5 %-аар өссөн байна.

Тусгай зөвшөөрөл бүхий хоршоодын нэгж гишүүнд дунджаар 1.4 сая төгрөгийн зээл оногдож байна.

/График-6/

2.4.Зээлийн эрсдэлийн сангийн хүрэлцээ

ЗЭЭЛИЙН АНГИЛАЛ	ЗЭЭЛИЙН ДҮН	Эрсдэлийн сан байгуулах хувь	Байгуулбал зохих дүн	Байгуулсан дүн	Зөрүү
8. Нийт зээл	17,238,823,723.44				
8.1.Хэвийн зээл	15,317,703,279.25	0%	0.00	-	
8.2.Хугацаа хэтэрсэн зээл	748,311,062.81	5%	(37,415,553.14)	-	
8.3.Чанаргүй зээл	1,172,809,381.38			-	
8.3.1. Хэвийн бус	259,532,107.88	40%	(103,812,843.15)		
8.3.2. Эргэлзээтэй зээл	252,808,113.38	75%	(189,606,085.04)		
8.3.3. Муу зээл	660,469,160.12	100%	(660,469,160.12)		
НИЙТ	16,271,097,324.44		(991,303,641.45)	(967,726,399.00)	23,577,242.45

Нийт тусгай зөвшөөрөл бүхий хоршоод нь Монгол банкны ерөнхийлөгч, Сангийн сайдын 2004 оны хамтарсан 207/459 тоот тушаалаар батлагдсан “Активийг ангилал, активийн эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам” болон уг журамд 2006 онд оруулсан нэмэлт өөрчлөлт (хамтарсан 147/94)-ийн дагуу ангилал хийж, 991,303,160.12 төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулахаас 967, 726,399.0 төгрөгийн эрсдэлийн санг байгуулж 23,577,242.45 төгрөгөөр дутуу байгуулсан байна. Нийт активт эзлэх зээлийн эрсдэлийн сангийн хэмжээ 3 %-тай байна.

ГУРАВ.ЭХ ҮҮСВЭР, ТҮҮНИЙ БҮТЭЦ


3.1.Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтэц

ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		2007-II	2007-III	Нийт активт эзлэх хувь
1. ӨР ТӨЛБӨР		22,760,879,361.61	26,407,572,623.94	82.1%
I	ХАДГАЛАМЖ	21,093,390,906.95	23,888,907,756.16	74.3%
	1. Хугацаагүй	2,544,879,657.08	2,529,929,104.49	7.9%
	2. Хугацаатай	18,548,511,249.87	21,358,978,651.67	66.4%
II	БОГИНО ХУГАЦААТ ЗЭЭЛ	178,773,941.76	754,108,400.95	2.3%
III	БУСАД БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,422,053,067.90	1,618,951,660.93	5.0%
IV	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	66,661,445.00	145,604,805.90	0.5%
2. ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		4,703,544,044.50	5,754,117,046.92	17.9%
V	ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ	4,600,402,042.80	5,320,962,868.96	16.5%
VI	ХОРШООЛОГЧДЫН ӨМЧ	103,142,001.70	433,154,177.96	1.3%
	15.Сангууд	456,644,683.19	622,628,070.06	
	16.Тайлангийн үеийн ашиг/алдагдал	1,586,767,074.03	1,757,312,013.45	5.5%
	17.Хуримтлагдсан ашиг/алдагдал	(1,940,269,755.52)	(1,946,785,905.55)	-6.1%
ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ ДҮН /1+2/		27,464,423,406.12	32,161,689,670.87	100.0%

Тусгай зөвшөөрөл бүхий хадгаламж, зээлийн хоршоодын 2007 оны 3 дугаар улиралын нэгтгэлийн өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүнгийн өсөлт нь ХЗХ-дод тусгай зөвшөөрөл олгож буй механик өсөлттэй холбоотой юм.

3.2. Эх үүсвэрийн бүтэц

/График-7/




Тайлант хугацаанд нийт эх үүсвэр баланс өсөж байгаа нь тус Хорооноос хоршоодод хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож байгаатай холбоотой юм. Хоршоодын өөрийн хөрөнгийн дундаж өсөлт улиралд дунджаар 1.23 тэрбум төгрөг буюу 21.4%, татан төвлөрүүлсэн хөрөнгийн дундаж өсөлт 7.2 тэрбум төгрөг буюу 27.3%-аар өссөн байна.

3.3. Хувь нийлүүлсэн хөрөнгө

Хадгаламж, зээлийн тусгай зөвшөөрөл бүхий хоршоодын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээр нь ангилж үзвэл дараах байдалтай байна. /График 8/ Үүнд:


/График-8/



Нийт ХЗХ-дын хувьд хувь нийлүүлсэн хөрөнгө нь өмнөх улиралаас 13.5%-аар буюу 720.6 сая төгрөгөөр өссөн дүнтэй байна.

Хадгаламж, зээлийн хоршоодын тайлант хугацаанд нийт татсан хадгаламжийг бүтцээр нь ангилбал доорх /график-9/ байдалтай байна.

/График-9/



ХЗХ-дын 2007 оны 3 дугаар улирлын байдлаар хугацаагүй хадгаламж өмнөх улиралаас 0.6%-аар буюу 14.9 сая төгрөгөөр буурсан байна. Харин хугацаатай хадгаламж 15.15%-аар буюу 2.8 тэрбум төгрөгөөр өссөн дүнтэй байна.

Харин нийт дүнгээрээ хадгаламж өмнөх улиралаас 11.7%-аар буюу 2.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.

ДӨРӨВ.АШИГТ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

4.1.Ашигт ажиллагааны талаар /хавсралт-3/

ХЗХ-д тайлант хугацаанд нийт 1,757.3 сая төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан нь өмнөх улиралтай харьцуулахад /өмнөх улиралын цэвэр ашиг 1,586.8 сая төгрөг/ 9.7 % буюу 170.5 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Тайлант онд тодорхой хэмжээгээр ашигтай ажилласан 74 ХЗХ байгаа нь нийт ХЗХ-дын 56.5 хувийг эзэлж байгаа ба тэдгээрийн ашиг 12.8 мянган төгрөгөөс 1.5 тэрбум төгрөгийн хооронд хэлбэлзэж байна.

Харин 21 ХЗХ буюу нэгтгэлд хамрагдсан нийт ХЗХ-дын 21.9 хувь нь алдагдалтай ажилласан байна.

Алдагдалтай ажиллаж байгаа зарим шалтгааныг нь тодруулж авч үзвэл, эрхэлж буй үйл ажиллагааны онцлог болон үйл ажиллагааны зардал өндөртөй байна.

ХЗХ-д нийт 2,005.5 сая төгрөгийн ашгийг хуримтлуулан тооцсон ба 248.2 сая төгрөгийн алдагдалыг хуримтлуулан тооцсон байна. Энэхүү ашигтай ажилласан 74 ХЗХ-дын нийт ашгийн 73.3 %-ийг буюу 1.5 тэрбум төгрөгийг Номин юнион ХЗХ-ны ашиг бүрдүүлсэн байна. ХЗХ-дын нийт ашгийн нэгж хоршоонд ноогдох арифметик дундаж ашиг 27.1 сая төгрөг байна. Харин нэгж хоршоонд ноогдох дундаж алдагдал нь 11.8 сая төгрөг байна.

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН ГАЗАР